

Улирч гэрлэх ёс ба “Монголын нууц товчоон” дахь Бэгтэр, Тэмүжин нарын зөрчил

Гончигийн Батсуурь 

Монгол Улсын Боловсролын Их сургуулийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургуулийн Уран зохиолын тэнхимийн
багш, доктор (Ph.D), Монгол Улс, Улаанбаатар

Хүлээн авсан - Received:
2025-04-08

Засварласан - Revised:
2025-05-19

Хэвлэгдсэн - Published:
2025-06-10

batsuuri@msue.edu.mn

ORCID: [0009-0004-7784-0988](https://orcid.org/0009-0004-7784-0988)



© 2025, Author(s)

Хураангуй: Энэхүү өгүүлэлд монголчуудын үхэгсдээ оршуулах хойлгын ёс ба улирч гэрлэх (левират) ёсны уламжлал хийгээд “Монголын нууц товчоон”-ны Бэгтэр, Тэмүжин нарын зөрчлийг тайлбарласан байна. Ингэхдээ Тэмүжин бага насандаа өөрийн эцэг нэгтэй ах Бэгтэрийн дүү Хасарын хамтаар хөнөөсөн нь улирч гэрлэх ёстой холбоотой, учир нь Бэгтэр өсөж том болоод Өэлүн эхийг хатнаа болгон авах улмаар хиад боржигоны эзэн болох магадлалтай байсан тул ийнхүү ахыгаа өөрийн замаас зайлуулсан нь нэг талдаа улирч гэрлэх ёс, нөгөө талдаа улс төрийн шийдэл хийсэн тухай өгүүлсэн байна.

Түлхүүр үг: Хойлгын ёс, олдвор, улирч гэрлэх ёс, левират гэрлэлт

ОРШИЛ

Төв Азийн өндөрлөгт олон зуун жилийг элээн амьдарч ирсэн монголчуудын түүх урд эртний улбаатай. Аливаа ард түмний гарвал угсаа хийгээд соёл суртахууныг таних хэд хэдэн чухал үзүүлэлт байдгийн нэг нь оршуулгын зан үйл гэж үздэг. Олон зууны турш нүүдэлчин хэв маягаар амьдарч ирсэн монголчуудын хувьд эрт ба дунд үедээ булшлан оршуулах зан үйл түгээмэл байсан нь археологийн судалгаагаар батлагдсан зүйл юм. Эрт ба дунд үедээ хойлго ёс үйлдэж байсан нь ч мөн археологийн судалгаагаар нэгэнт батлагдсан. Хойлго (qoyıɣa) гэдэг нь үхэгсдийн араас хүн, мал амьтан, эд өлгийн зүйлийг дагалдуулан хамтад нь оршуулах өвөрмөц ёс юм. Энэхүү ёс хэрхэн бий болсон тухай асуудал нь амьдралын хэв маяг, итгэл бишрэл, зан заншил, соёл суртахуун..., гээд ихээхэн өргөн хүрээтэй, асуудал бөгөөд урт хугацаандаа хүн анхлан үүссэн үеэс улбаатай хэмээн хэлж болно.

Монголчуудын булшинд тухайн үеийн голлох аж ахуйн хийгээд амьдралын хэв маягтай холбоотой зүйлүүдийг дагалдуулан оршуулдаг байсан нь харагддаг. Тухайлбал эрэгтэй хүнд зэр зэвсэг, эмээл хазаар, хэт цахиур..., зэргийг хийдэг бол эмэгтэй хүнд гоёл чимэглэлийн зүйл, хайч, толь, сам, ээрүүлийн дугуй, дамар дагалдуулахаас гадна нөхөрт гарсан эхнэр хүнд бол богтаг малгай тавина. Хүүхдийн оршуулгад эд өлгийн зүйл дагалдуулахгүй, шагай чөмөг, нуруу дагалдуулдаг байжээ.

Монгол нутгаас олдсон хамгийн эртний үед хамаарах булшны зүйл нь Неолитийн булшнууд юм. Энэ тухай “Монголын археологийн өв” цувралын 3-р ботид “Монгол Улсын нутгаас илэрч олдсон булш оршуулгын дурсгалын хамгийн эртнийх неолитийн төгсгөл үед холбогдоно. Неолитийн булшнууд НТӨ 4000 орчим жилийн үед холбогдох болохоор монгол нутаг дээр амьдарч байсан

эртний хүмүүс одоогоос 6000 гаруй жилийн өмнө нас барсан хүнээ зориудаар оршуулж, хүндэтгэх, гашуудах зан үйл гүйцэтгэж байсны гэрч билээ” (Алдармөнх.П, 2016, р. 13) гэж дурдсан байдаг. Тэгвэл монгол нутагт анхны төр улс байгуулсан нь тодорхой мэдэгдэж байгаа нь Хүннү нар юм.

1.Судалгааны тойм:

Хүннүгийн булшны олдворыг эрдэмтэн судлаачид чамгүй судлан дүгнэсэн. “Монголын эртний түүх” цуврал таван ботийн тэргүүн буюу “ХҮННҮ” хэмээх ботид “Монгол нутагт байгаа Хүннү булшнаас 400 орчмыг малтан судалсан ба 170 орчим булшны судалгааны дүнг хэвлэн нийтэлжээ” (Батсайхан.З., 2017, р. 15) хэмээн тэмдэглэсэн байгаагаас үзвэл Хүннү нарын булшны судалгаа нэлээдгүй өргөн хүрээтэй явагдсан болох нь харагдана. Эрдэмтэн судлаач Ц.Төрбат «Хүннүчүүдын дунд адуу малаас гадна хүнээр тахилга өргөх явдал байсан ба гол төлөв насанд хүрсэн эрэгтэй хүнийг хүүхэд болон залуу эмэгтэйчүүдийг хойлголон оршуулдаг байжээ» (Төрбат.Ц., 2004, р. 102) байна. Энэхүү ёс хойшид уламжилсан болохыг археологийн олдворууд болон бичгийн дурсгалууд гэрчилдэг. Эрдэмтэн судлаач Х.Пэрлээ «Эрт цагт монголчууд үхэгсдээ анч нохой, морь, агнуурын зэвсгийг дагалдуулан хамт булдаг байсан бол XIII зууны үед үхэгсдээ оршуулахдаа үлэмжхэн тооны үнэ бүхий зүйлс хамт хийж, хүн, малыг олноор алж дагуулах болжээ» (Пэрлээ.Х., 1956, р. 7) гэж бичсэн байдаг. Тухайн үеийн хүмүүс бүх л зүйлийг эзэн тэнгэр хийгээд өөрийн сүнстэй хэмээн үзэж байсан агаад эзэн үхвээс эдэлж хэрэглэж байсан бүхнийг нь алж, эвдэж хамтад нь булдаг байсан бөгөөд жишээ нь ууж байсан аягыг нь эмтлэх, эмээл хазаарыг нь хаа нэг газар нь гэмтээх, хайртай морьдыг нь алах, халамжит хатад, шивэгчдийнх нь амийг тэвчих., гэх мэтээр өөрөөр хэлбэл сүнсийг нь гаргаж хамтад нь булдаг байжээ. Энэ ёс олон зуун жилийг элээн уламжилсан агаад бүр хожуу хориглогдсон байдаг.

Академич Ш.Бира “Хутагтай Сэцэн тайжийн зохиосон нэгэн хуулийн тухай” өгүүлэлдээ “Энэ өдрөөс эхлэн ялангуяа Монгол, цахарт цааз тогтоох нь: Урьд монгол улс үхэгсдийнхээ хойноос чинээ чинээгээрээ өөрийн эхнэр, зарц, боол, морь мал тэргүүтнийг алж байв. Үүнээс хойш алах орон болсон мал тэргүүтнийг дор дорын санаагаар хувраг, лам нарт өргөхтүн. Зориулга, ерөөл айлтга. Үхэгсдийн хойтоход зориулж амийг бүү тасал. Хэрэв урьдын адил хүн албаас цаазаар амь насы нь цээрлүүлэхтүн. Хэрэв морь малыг албаас цаазаар бүх хөрөнгийг хураахтун” (Бира.Ш., 1970, pp. 14-19) гэсэн байна. Дээрх судалгаануудаас үзвэл монголчуудын өвөг дээдэс хойлгодох ёсыг нэн эртнээс ХҮI-ХҮII зууны үе буюу Буддын шашин дэлгэрэх үе хүртэл хэрэглэж байгаад цаазаар хориглогдсон болох нь харагдаж байдаг.

2.Судалгааны үр дүн:

Энэхүү хойлгын зан үйлтэй зэрэгцээд улирч гэрлэх нэгэн ёс (Levirate marriage) байсан нь мөн харагддаг. Мөнхүү ёсны тухай «Левират гэрлэлт нь нас барсан эрэгтэйн ах нь дүүгийнхээ бэлэвсэн эхнэртэй гэрлэх үүрэгтэй гэрлэлтийн төрөл юм. Левират гэрлэлтийг экзогам гэрлэлтийг (өөрөөр хэлбэл овгийн гадна гэрлэлтийг) хориглодог овгийн бүтэц хүчтэй үйлчилдэг нийгэмд хэрэгжүүлдэг» гэсэн буй ба энэхүү улирч гэрлэх ёс нь нүүдэлчдийн дунд түгээмэл байсан тухай баримт бий. Тодруулбаас, “Сыма Цянь-аас эхлээд хятадын соёлд байдаггүй нүүдэлчдийн нэгэн өвөрмөц ёс заншлын талаар сурвалжид тэмдэглэгдсээр иржээ. Тухайлбал, хэрэв аав нь үхвэл хүү нь хойд эхтэйгээ гэрлэнэ, хэрэв ах нь үхвэл дүү нь түүний бүх эхнэрийг авдаг бөгөөд энэ нь тухайн ургийн удам угсааг таслахгүй үргэлжлүүлэх зорилготой байжээ” (Таскин.В.С., 1968, р. 46) гэсэн байдаг агаад энэхүү улирч гэрлэх ёс нь овог аймаг хүчирхэг байх, олуул байх хүсэл эрмэлзэлтэй

шууд холбоотой агаад тухайн овог аймаг хүчирхэг байх нь хүн амын тооноос шууд хамааралтай байжээ.

Домог зүйн баримтууд хийгээд эртний тайлга, тахилгын зан үйлийг судалгаанаас үзэхэд хоёр л зүйлийг тахилга голлох байртай байсны нэгдэх нь нар хурыг хүсэмжлэх буюу хоол тэжээлтэй байхуйн тухайтад, хоёр дахь нь үржих олон болохуйн тухайтад байсан болох нь мэдэгддэг. Хадны сүг зурагт овгоороо хурьцаж буйг дүрслэн үлдээсэн нь түгээмэл байдгийн учир ч үүгээр тайлбарлагдах учиртай. Дурдсан улирч гэрлэх ёс нь Хүннү төдийгүй төв Азийн түрэг, монгол эртний нүүдэлчин овог аймгуудын дунд түгээмэл дэлгэрсэн агаад өдгөө түүнийг хадгалж үлдсэн нь түрэг угсаат хасагууд юм. Улирч гэрлэх ёсны бас нэгэн тал нь ураг элкэнд багтан орж ирсэн бэрийг төрхөмд нь буцаалгүй асран тэжээх ёс агаад энэ ёс эртний уламжлалтай ч харьцангуй хөгжиж ирсэн үед мөн ёс үүссэн байх талтай бөгөөд үхсэн эзэн буюу аав, ах, дүүгийн хойноос бүхий л эд хэрэглэл хийгээд эхнэр, хатдыг алж хамт булах ёс нь нэлээд бүдүүлэгт тооцогдох бол үлдээсэн өвийг нь дараагийн залгамжлагч авдаг болсон нь хүний ухамсрын хөгжлийн дараагийн үе шатанд хамаарна. Алуулах гэж байгаа эхнэр, хатдын талаас бодсон ч үлдэж байгаа залгамжлагч талаас бодсон ч улируулан авах нь мэдээж туйлын ашигтай хувилбар юм.

Мөнхүү ёс уламжлалын талаар хэлний баримтуудад уламжлан үлдсэн байдаг. Тодруулбаас, “Эцгийгээ ал, Эхийгээ ох” гэх хараал болон “эхнэр” зэрэг үгс үүнд хамаарна. “Эцгийгээ ал, эхийгээ ох” гэдэг хараалыг судлаач Ш.Одонтог “Европ, Азийн олон үндэстний нэг адил бидний өвөг дээдэс хөгжлийн тухайн цагтаа улирч гэрлэдэг байжээ. Өв залгамжлагч нь ах, эцэг, дүү (зарим тохиолдолд эзэн)-гийн нас эцэслэсний хойно бага хатад татвар эмсийг нь өв болгож өөртөө авдаг ёстой байв. Хүн төрөлхтний ургийн түүхэнд анхандаа тэнгэрт цугт нь очуулахаар талийгаачийн хамт боол зарц, эхнэр эмсийг хөдөөлүүлж байгаад (дэр болгох) хөгжлийн явцад өв залгамжлагч өөртөө авдаг болсон ч уул ёс бас халагдсан байна. Харин нийгэм хөгжихийн хэрээр эл заншлын талаарх ойлголт эрс өөр болж ирснээр ёс журамгүй этгээдийг дээрх мэт хараах болжээ” (Одонтог.Ш., 1996, р. 70) гэж тайлбарласан байна. Энэ нь хараал нь левират буюу улирч гэрлэх ёстой холбоотой, цаад утга мөн чанартаа хорио цээрийн шинжтэй байна.

Харин “Эхнэр” гэх үг нь эх гэдэг үгийн олон тооны хэлбэр багш нар, эмч нэр гэдэг шиг эх нэр гэсэн үг бөгөөд эл үгийг академич Б.Ренчин “...эцгийг амьд байхад хүүд нь эцгийн олон эм цөм эхнэр байсан болно. Чингээд эцгийг нас элэгдэхэд, өөрийн төрсөн эхээс бусдыг эцгээсээ өвлөж, гэргий болгодог учир эцгийн сэрүүнд олон эмсий нь эхнэр гэж нэрлэж байсан нэр нь сүүлдээ суудаг болсон эмсийн нэр болж, төрсөн ганц эх, бусад дэр нийлэх болсон эхнэр (ээжүүд) нь тэр эхнэр нэрээрээ эх гэдгээс ялгаатай болоод, хожим ганц эм хүнтэй суух ёс голлоход, ганц аваали эмээ мөн эхнэр гэж нэрлэдэг болж ирсэн” (Ренчин.Б., 1967, р. 58) гэж дурьдсан буй. Өөрөөр хэлбэл Чингис хаан дөрвөн хатантай, Чингис хааны ууган хүү Зүчийн хувьд Бөртэ хатан, Хулан хатан, Есүй хатан, Есүгэн хатан дөрвийг нийтэд нь ээжүүд буюу эх нэр хэмээн нэрлэнэ. Улирч гэрлэх ёсоор бол Их хааныг тэнгэр болоход том хүү нь өөрийн ээжээс бусдыг хатнаа болгон авах учиртай бөгөөд авдаг ч байж, он цаг улирч хүний нийгэм хөгжихийн хэрээр соёлжиж өөрийн ээжийг эх гэж нэрлэх болсон бол нөгөө олон тоо заасан эхнэр гэдэг үг нь авсан ганц эмийг заасан нэр болж тогтжээ.

Аман зохиолд мөн ёстой холбоотой баримтууд бий. Жишээ нь, “Алтан мөнгөн аргай” үлгэрт Наян настай Намтай мэргэн өвгөн Мангас хар эмгэнд найман настай хүүгээ өгөхөөр тогтдог, гэтэл намайн настай Чагаа хүү амь зулбан тэмцсээр эцэстээ гэртээ ирж “Аргай аргай түг” гээд аавынхаа толгойг хага цохилж алаад ээжтэйгээ хамт амар сайхандаа жаргажээ хэмээн өгүүлдэг нь ч тохиоллын дүрслэл бус.

Ер нь эрт ба дундад үеийн эмэгтэй хүн ялсан баатрын эхнэр болон суухаас өөр аргагүй магадгүй ингэх ч ёстой байсан нь харагддаг агаад тэр нь тухайн эмэгтэйдээ сайхан, өөрөөр хэлбэл сайхан амьдрах боломж нь байсан нь харагддаг. Эмэгтэй хүн бие даан шийдвэр гаргах эрхтэй, эр хүнд харьяалагдахгүй амьдрах боломжтой болсон нь бүр XX зууны хоёрдугаар хагасаас эхэлсэн байдаг. XIII зуунаас шууд уламжилсан бичгийн дурсгал болох “Монголын нууц Товчоон”-д Бэгтэр, Тэмүжин нарын зөрчил нэлээд хурцаар дүрслэгдсэн байдаг. Тухайлбал, “Тэндээс Тэмүжин Хасар хоёр үл таалан өгүүлрүүн өчигөн нэгэнтээ билжүүр годилдсоныг тийнхүү булиж авлаа. Эдүгээ бас тийнхүү булив. Хамт хэр алдахун бид хэмээгээд үүдэн оорч гарч ёрчив. Бэгтэр улхан дээр шарга агт-тан есөн морь харж суу(н) бүхүйд Тэмүжин үмрээс далдлаж Хасар өмнөөс далдлаж сумаа салбаж хүрэхүйд Бэгтэр үзээд өгүүлрүүн Тайчигуд ах дүүгийн гашуун дуусан ядан ач хэнээ авран чадахун уу хэмээж бүхүйд намайг яахин нүдний сормуусан амны хахсан болгомуй та. Сүүдрээс бус нөхөр үгүй сүүлээс бус чичуга үгүйд яахин тийн сэтгэв та. Голомт мину бүү бүрэлгэдхүн. Бэлгүдэйг бүү тэвчидхүн хэмээгээд завилан сууж хүлцэв. Тэмүжин Хасар хоёр өмнөөс үмрээс үтэрмэлж одов” (Редактор Ш.Чоймаа, 2023, р. 152) хэмээн дүрсэлсэн бөгөөд ийнхүү Бэгтэрийг хөнөөдөг. Өгүүлэн буйгаар бол нэгэн гэгээн сугас загас болон бялзмарыг булаалдсан учир хөнөөсөн хэмээдэг авч энэ нь туйлын эргэлзээтэй. Улирч гэрлэх ёсоор бол Есүхэй баатрын Их хатан Сочигэл эхийн хүү Бэгтэр Өгэлүн үжинг хатнаа болгон авч Есүхэй баатрын орыг залгах учиртай. Чухам үүнийг сайтар мэдэж байсан учир Тэмүжин өөрөө араас нь, дүү Хасарыгаа өмнөөс нь очуулж хөнөөсөн байх талтай. Ийнхүү Бэгтэрийг алсан нь хоногийн хоолны төдий өчүүхэн асуудал биш, өөрийн хаан болох замыг зассан хэрэг байж болно. Бэгтэр Өгэлүнг хатан болгон авахгүй байлаа ч гэсэн Тэмүжинээс насаар ах учир түүний замд саад болох нь эргэлзээгүй байжээ. Энэ бол “Монголын нууц товчоон” хэмээх гипертекстийн олон нууцуудын зөвхөн нэг нь.

Мөн үйл явдалтай холбоо бүхий нэгэн бол Мөнлиг эцэг. “Монголын нууц товчоон”-д “Есүхэй баатар өгүүлрүүн дотор мину муй буй. Дэргэд хэн буй хэмээж Хонхотадай Чараха эбүгэний хөвүүн Мөнлиг ойр буй хээвээс (хэмээвээс) урьж ирүүлж өгүүлрүүн чага мину Мөнлиг хөвүүд өчүүхэт бүлэгэ. Би хөвүүгээ Тэмүжинийг хүргэдэд талбиж ирүүн зуур Татар иргэнээ ойслогдоо би. Дотор мину муй буюу. Өчүүхэд хоцрогсод дүү нэрээ бэлэвсэн бэргэнээ асрахыг чи мэд. Хөвүү мину Тэмүжинийг үтэрхэн одож авч ир. Чага мину Мөнлиг хээгээд (хэмээгээд) нөгчив” (Редактор Ш.Чоймаа, 2023, р. 139) хэмээсэн буй. Өгүүлснээр бол Есүхэй баатар эхнэр хүүхдээ Мөнлигт гэрээслэн үлдээсэн буй бөгөөд “Монголын нууц товчоон”-д Мөнлигийг цаашид дурдахдаа Мөнлиг эцэг хэмээн дурддаг. Үүнээс нь Мөнлиг Өгэлэн үжинтэй хожим ханилж Тэмүжин хийгээд дүү нарынх нь хойд эцэг болсон байх талтай гэх таамаг ч гарсан буй. Есүхэй баатар Бэгтэрийг байсаар байтал Тэмүжин хүүгээ арай илүү үзэх ямар нэгэн шалтгаан байсан бололтой байдаг бөгөөд үүнтэй холбоотойгоор Өгэлүн үжинийг булаан авсантай тухай нэгэн хэрмэл домог буй. Тодруулбаас, Есүхэй баатар ан хийж яваад Өгэлүн үжиний шээсэн мөрийг олж үзээд энэхүү шээгээд одсон эмээс дэлхийг эзлэх хүү төрнө хэмээн зориуд булаан авсан гэсэн утга бүхий юм.

Бэгтэр, Тэмүжин нарын үйл явдлын талаар манай зохиолч, Соёлын гавьяат зүтгэлтэн Г.Аюурзана “...Бэгтэр бээр Тэмүжиний гол өрсөлдөгч, хэрэв насаар нэг ахмад асан бол угсаа залгамжлагч болж таарах гээд байдаг. Есүхэйнхний өмч есөн адуу Бэгтэрийн мэдэлд байсан нь, мөн үхэхийн өмнө ноён суудлаар ихэмсэг завилж суугаад “Голомтыг минь минь бүү бүрэлгэгтүн! Бэлгүдэйг бүү тэвчигтүн!” хэмээн захин гэрээсэлж буй нь ч насаар ахмад гэдгийг нотлоод байх шиг” (Аюурзана.Г., 2019, р. 73) гэх буюу «Тэр үеийн монголчуудын хувьд эцэг, авга, ахынхаа бэлэвсэн эхнэрийг хүү, зээ, дүү нь уламжлан гэрлэдэг ёс бий тул Бэгтэр насанд хүрээд Өөлүн үжинтэй гэрлэх нь тодорхой байв. Тэгвэл

Тэмүжиний хойд эцэг төдийгүй Хиад иргэний тэргүүлэгч болох нь гарцаагүй тул томоогүй хүүхдийн болчимгүй хэрүүл мэтээр үзүүлсэн энэ явдал чин үнэндээ бол ордны эргэлт ч байх магадлалтай” (Аюурзана.Г., 2019, р. 74) гэж өгүүлсэн байна.

ДҮГНЭЛТ

Энэ бүхнээс дүгнэж үзвэл Бэгтэр нүүдэлчдийн уламжлалт улирч гэрлэх ёсоор Өгэлүн үжинийг хатнаа болгон авч, Хиад Боржигоны тэргүүн, Есүхэй баатрын залгамжлагч болох байсан, үүнийг сайтар ухамсарлаж байсан Тэмүжин дүү Хасараа дагуулан өчүүхэн шалтаг төдийгөөр Бэгтэрийг хөнөөж, Бэлгүдэйг өөрийн мэдэлд авсан болох нь харагдаж байгаа юм. Насанд хүрээгүй хүүхдүүд тийн сэтгэж эс чадна гэж үзэж болох мэт боловч тухайн цаг үе нь өөрөө хатуу ширүүн, амьдралын хэв маяг нь үхэл сэхлийн өрсөлдөөн, мөн багадаа өнчирч хоцорсон хүү тэр байтугайг ухааран чадах боломжтой, тэгээд ч дэлхийг эрхшээсэн эзэнт гүрнийг байгуулсан суу билигт хааны ирээдүйн үйл хэргийг зүйрлэн санаваас тэр мэтийг үйлдэх нь энүүхэнд хэмээн үзнэ.

The Custom of Levirate Marriage and the Conflict Between Begter and Temuujin in "The Secret History of the Mongols"

Batsuuri Gonchig 

Ph.D, Lecturer of the Department of Literature, Mongolian National University of Education, Ulaanbaatar, Mongolia

Summary: This article explores the traditional Mongolian burial rites for the deceased and the custom of levirate marriage (widow inheritance), as well as the conflict between Begter and Temuujin in The Secret History of the Mongols. It explains that Temuujin, during his youth, killed his half-brother Begter with the help of his full brother Khasar. This act was closely tied to the levirate tradition, as Begter, upon reaching adulthood, could have claimed their mother, Uelun, as his wife—thereby gaining leadership over the Khiad Borjigin clan. Thus, Temuujin's elimination of his half-brother was both a political move and a response to the implications of the levirate custom. The article discusses how this event reflects the intersection of traditional marital practices and power struggles in early Mongol society.

Keywords: *Marriage customs, finds, intermarriage customs, levirate marriage*

Ном зүй

Алдармөнх П., Амартүвшин Ч., Б.Анхбаяр, Д.Батсүх, Н.Баярхүү, Ж.Гантулга, Ч.Ерөөл-Эрдэнэ, Т.Идэрхангай, Ц.Одбаатар, А.Очир, Ц.Төрбат, Д.Цэвээндорж, С.Энхболд, Д.Эрдэнэбаатар, У.Эрдэнэбат, Л.Эрдэнэболд, Г.Эрэгзэн. (2016). *"Монголын эртний булш, оршуулга" Монголын археологийн өв* (Vol. Боть. III). Улаанбаатар.

Аюурзана.Г. (2019). *Тэнгэрийн судар*. Улаанбаатар.

- Батсайхан.З., Д. (2017). *“Монголын эртний түүх”, Тэргүүн боть, “ХҮННҮ”*. Улаанбаатар: Соёмбо принтинг.
- Бира.Ш. (1970). *Хутагтай сэцэн тайжийн зохиосон нэгэн хуулийн тухай*. Улаанбаатар: Шинжлэх ухааны Академийн мэдээ.
- Одонтөр.Ш. (1996). *Монгол секс үгийн тайлбар*. Улаанбаатар.
- Пэрлээ.Х. (1956). *Эртний монголчуудын үхэгсдээ оршуулж байсан зан үйлийн асуудалд*. Улаанбаатар: Шинжлэх ухааны хүрээлэнгийн хэвлэл.
- Редактор Ш.Чоймаа, Ц. (Ed.). (2023). *Дэлгэрэнгүй тайлбартай Монголын нууц товчоон*. Улаанбаатар.
- Ренчин.Б. (1967). *Монгол бичгийн хэлний зүй*. Улаанбаатар.
- Таскин.В.С. (1968). *Материалы по истории сюнну*. Москва.
- Төрбат.Ц. (2004). *Хүннугийн жирийн иргэдийн булш*. Улаанбаатар : Соёмбо принтинг.